

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 3 ДУГААР САРЫН ТАЙЛАН

2022-03-24

Баруун-Урт

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын зүгээс иргэдэд түргэн шуурхай, чанартай үйлчилгээг үзүүлэхийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

МАНАЙ БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР ДАРААХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАСАН.

1. Тус Тамгын газарт ирсэн 33 бичиг / *Үүнээс-7 албан бичиг хугацаандаа явсан, хугацаа болоогүй-12 байна*/ явсан 34 бичиг байна. Мөн 3 сарын байдлаар сумын Засаг даргын “А” захирамж-26, “Б” захирамж-3 Тамгын газрын даргын “А” тушаал-1, “Б” тушаал-5 төлөвлөгдөж, баталгаажсан. Иргэдэд 11 лавлагааг гаргаж, бүртгэл хөтөлж ажилласан.
2. Сүхбаатар аймгийн хүний нөөцийн суурь судалгааг хугацаанд хийж хүргүүлсэн.
3. Байгууллагын дотоод журмыг шинэчилсэн.
4. 2022 оны 01 дүгээр улирлын ажлыг “үнэлгээний баг” дүгнэж, урамшууллын шаардлага хангасан албан хаагчдыг урамшуулж, ажлаа сайжруулах шаардлагатай албан хаагчдад зөвлөгөө өгч ажилласан.

. ХОЁР: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Сумын Онцгой комиссын 2022 оны 01-р хуралдааны шийдвэр, сумын **Засаг даргын 2022 оны А/ 49 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж 500-с доош малтай өрхүүдэд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлж байна.**

Үүнд:

- 8-р багийн 581 өрхөд 3200 боодол өвс ,
- 1,2,3,4,5,6,7,9-р багийн нийт 140 өрхөд 800 боодол өвс олгохоор шийдвэр гаргасан.

- 03-р сарын 21-ний өдрийн байдлаар 1-р баг 9 өрхөд 45 боодол, 2-р баг 6 өрхөд 30 боодол, 3-р баг 12 өрхөд 60 боодол, 4-р баг 10 өрхөд 50 боодол, 5-р баг 16 өрхөд 80 боодол, 6-р баг 20 өрхөд 10 боодол, 7-р баг 18 өрхөд 90 боодол, 8-р баг 220 өрхөд 1320 боодол, 9-р баг 20 өрхөд 100 боодол нийт 9 багт 331 өрхөд 1875 боодол өвс олгоод байна.
- 2. Бэлчээрийг хамгаалах зорилгоор өөрийн сумын малчдын нутаглаж байгаа Тал булгийн рашааны эх, Яргайтын булгийн эхийг хамгаалах зорилгоор 8,0 сая.төгрөгийг 2020 оны ОНХС-д тусган ажилласан. Яргайтын булгийн эхийг урт 150м, өргөн нь 100 м нийт 15000м² талбай буюу 1.5 га талбай, Тал булгийн рашааны эхийг урт нь 100 м, өргөн нь 100м нийт 10000м² талбай буюу 1 га талбайг хашиж хамгаалж мод тарих тооцоолсон.
Мөн Баруун-Уртын голын эхийн 15 га газрыг хашиж хамгаалах саналыг НҮБ-н ногоон сангаас хэрэгжүүлж буй **“Уур амьсгалын өөрчлөлтөд Монгол орны хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг сайжруулах нь”** төсөлд танилцуулсан.
- 3. 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 50,0 сая.төгрөгөөр ДУК машин худалдан авахаар төлөвлөгдсөн. Бэлчээр ариутгалын ДУК машины техникийн тодорхойлолтыг боловсруулсан. Худалдан авах тендерийг зохион байгуулах ажлын хэсэг Сумын Засаг даргын 2022 оны А/58 дугаар захирамжаар байгуулагдсан. Ажлын хэсэг 2022 оны 03-р сарын 21-ний өдөр хуралдаж тендерийн бичиг баримтыг боловсруулан зарласан. Тендерийг нээх хугацаа 03-р сарын 28-ны өдөр хийгдэнэ.
- 4. НҮБ-н ногоон сангаас хэрэгжүүлж буй **“Уур амьсгалын өөрчлөлтөд Монгол орны хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг сайжруулах нь”** төслийн нээлт Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт суманд 2022 оны 03-р сарын 15-ны өдөр зохион байгуулагдсан. Дээрх төслийн хүрээнд **Баруун-Урт суманд ХАА-н цогцолборыг байгуулахад дэмжлэг хүсэх чиглэлээр 414,0 сая. төгрөгийн төсөвтэй төслийн саналыг танилцуулсан.** Дээрх төсөлд 10 га газарт ногоон тэжээл тариалах, 1,5 га талбайд төмс хүнсний ногоо тариалах, 1 га талбайд мал үржүүлгийн газар байгуулах, 1 га талбайд

тэжээлийн агуулах байгуулах, 6,5 га талбайд мод үржүүлгийн газрыг байгуулах тооцоолол хийсэн.

ГУРАВ. ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН

ШУУРХАЙ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 1-р улирлын байдлаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар **2023 онд хийгдэх ажлын санал асуулгыг 1035 иргэнээс** аваад байна.
- Алдарт эхийн одонгийн материалыг хүлээн авах, бүрдүүлэх ажлыг хийж байна. Одоогоор 9-н баг нийлээд болзол хангасан **100 эхийн материалыг хүлээн авсан** байна.
- Баруун-Урт сумын ИТХ-ын 2021 оны 09 тоот тогтоол **“Зөв амьдрал-Зөв хэвшил” хөтөлбөрийн** хүрээнд Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газраас 1 сарын аян зохион байгуулж, олон нийтэд амьдралын буруу хэвшил, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, түгээн таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Зөв хэвшил-Зөв амьдрал аяны хүрээнд 50 иргэн зөв дадлыг хэвшүүлэх сургамжит онч үг бичиж оролцсон. Архигүй-Аюулгүй-Айдасгүй аянд 7 байгууллага, 5 анги хамт олон нэгдсэн. Мөн энэхүү хөтөлбөрийн хүрээнд **“ АЮУЛГҮЙ АРХИГҮЙ, АЙДАСГҮЙ БАРУУН- УРТ “** хөтөлбөрийн хүрээнд багийн хэмжээнд болон цахим орчинд 38 удаагийн постоор бэлтгэн иргэдийг уриалан ажилласан.
- Багийн хамтарсан багийн гишүүдийг хуралдуулж 2022 оны хийх ажлын төлөвлөгөөг гаргасан байна. 14 кэйстэй танилцаж нөхцөл байдлын үнэлгээ хийгдэж байна.
- Иргэдийн хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 3 болон 9-р баг 7 хоног бүрийн Бямба гаригт 13:00 цагт заалны цаг нээлттэй болсон. Нийт-47 хүн хамруулж ажилласан.
- Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ААН, байгууллагатай Багийн засаг дарга, хэсгийн байцаагч, аж ахуй нэгжийн дарга ,эрхлэгч нарын **нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, оролцоог хангах зорилгоор хамтран ажиллах гэрээг 22 байгууллагатай** байгуулсан.
- Багийн Засаг даргын тодорхойлолт авахаар 259 иргэн үйлчлүүлсэн.

8. Төрийн үйлчилгээний оператор E-Mongolia цахим системийн лавлагаа үйлчилгээг түргэн шуурхай иргэдэд гаргаж үйлчилж байна. **Төлбөртэй-2, төлбөргүй-30 нийт 32 ш лавлагаа үйлчилгээг** үзүүлсэн байна.

- Иргэний үнэмлэхний лавлагаа-13
- Оршин суугаа газрын лавлагаа-5
- Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-4
- Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа-4
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа-3
- Иргэн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт-1
- Жолооны үнэмлэх захиалга-1
- Жолооны үнэмлэх хуулбар-1

9. Дараах тусламж, дэмжлэгийг үзүүлж ажилласан.

- “Амьддаа бие биенээ хайрла” хандивын тоглолтын билетийг багийн зорилтот бүлгийн 11 иргэнд өгсөн.
- “Жаргаж амьдраарай тоглолтын билетийг 15 иргэнд өгсөн.
- Аймаг, сумын төлөөлөгч нартайгаа хамтран 2 өрхөд 4 ханатай гэр, 8 өрхөд хагас тоон нүүрс, 12 өрхөд хүнсний дэмжлэг үзүүллээ.

ДӨРӨВ : ХОТ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ,

ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах Хөдөө аж ахуйн паркийн хашааны урд талд байрлах үйлдвэрийн зориулалттай 0,8 га, 8-р багийн нутаг дэвсгэрт байрлах 16-н нэгж талбар бүхий 0,25 га газрыг төмс хүнсний ногооны зориулалтаар, 4-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Бат хүлэг” авто засварын зүүн талд байрлах 0,25 га газрыг үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар, 8-р багийн нутаг дэвсгэр Хайлааст-Үүдэнд байрлах тус бүр үйлдвэрийн зориулалттай 2 га газрыг дуудлага худалдаанд оруулахаар сумын Засаг даргын захирамжийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан.

2. Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан 8-р багийн нутаг дэвсгэр Хайлааст-Үүдэнд байрлах 23,1 га газрыг сумын Засаг даргын тамгын газарт газар олголт хийж гүйцэтгүүлээд байна.

5. Сумын Засаг даргын захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдон Сүхбаатар тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ болон Уртын гэгээ ОНӨААТҮГ газруудын эд хөрөнгийн тооллогын ажлыг хийж гүйцэтгэн тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн.

7. Нийтийн эзэмшлийн 12 авто зогсоол, **45054,36м²** явган хүний зам, **27,69км** авто зам, **3км** урттай шуудууг хуваарийн дагуу тогтмол цэвэрлэж нийт 42 орчим тонн хогийг хогийн нэгдсэн цэгт хүргэж ажилласан.

8. Золбин нохой устгах ажлыг 7 хоног бүрийн даваа, лхагва, баасан гаригт зохион байгуулж сард **нийт 68 нохой устгасан.**

9. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2019 оны А/247 тоот “Аймгийн төвөөс мал гаргах” захирамжийн дагуу өдөр бүр малыг хотын төвөөс гаргах ажлыг зохион байгуулж энэ сард давхардсан тоогоор нийт 275 мал гаргасан.

Үүнд: 50 адууг хотын төвөөс тууж гаргасан бол, 15 адууг хашсан. 150 үхэр хотын төвөөс 5км газар тууж гаргасан бол 60 үхэр байгууллагын мал түр хашсан.

ТАВ: САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Сум хөгжүүлэх сан

Хоршоо хөгжүүлэх сангийн хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, зээлийн хүү болон үндсэн зээлийн төлөлтөд тогтмол хяналт тавин зээлийн төлөлтийн хуваарийг тухай бүр хөтлөн ажиллаж байна.

Монгол банкны зээлийн мэдээллийн санд хоршоо хөгжүүлэх сангийн сар бүрийн зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг мэдээллийн системд оруулж нэмэлтээр программд 20 иргэний мэдээллийг бүрэн оруулан ажиллаж байна.

Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд дэх эвлэрүүлэн зуучлалд 6 хүний 57,366. 1 мянган төгрөгийн нэхэмжлэлийг шилжүүлсэн.

Хугацаа хэтэрсэн 6 хүний 19,799.2 мянган төгрөг, 2022 онд шүүхэд шилжүүлсэн 2 хүний 5,300.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн мэдээ 2022 оны 01 дүгээр сарын 27-ний өдөр, 03 дугаар сарын 18-ний өдөр сум хөгжүүлэх сангийн 5 жилийн мэдээг маягтын дагуу Сүхбаатар аймгийн төрийн аудитын газарт хүргэн ажилласан.

Орон нутаг хөгжүүлэх сан

2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/47 тоот захирамжаар 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх санал асуулгын хуудас эрэмбэлэх ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй хууль тогтоомжийн дагуу байгуулсан.

Сумын Засаг даргын А/50 тоот захирамжаар ногоон байгууламж, А/58 тоот захирамжаар ДУК авто машин нийлүүлэх ажил tender.gov.mn сайтаар зарлагдаж тендер хүлээн авах шатандаа, усны машины оролцооны ажил Дөрвөлж ХХК дээр зарлагдаж гүйцэтгэгч тодорч бараа хүлээн авах шатандаа явагдаж байна.

2022 оны 03 дугаар сарын 07-ний өдөр Тамгын даргаар удирдамж батлуулж удирдамжийн дагуу харьяа төсөвт байгууллагын нябо, нярав, аж ахуй нэгж, үнэлгээний хорооны гишүүд зэрэг 43 хүнд аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, сумын тамгын газрын санхүү албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн нар тус тус холбогдох зөвлөмж, мэдээллийг хүргэн ажилласан

БУСАД

1. НҮБ-н Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас хотуудын гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох, бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй “ **Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь**” санаачлагын хүрээнд Аймгийн төвийн сумын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх ажлын

хэсгийг Аймгийн Засаг даргын 2022 оны А/117-р захирамжаар байгуулж 2022 оны 03-р сарын 09,10 өдрүүдэд Аймгийн Онцгой байдлын газарт ажилласан. Ажлын хэсэг 17 хүний бүрэлдэхүүнтэй ба мэргэжлийн байгууллагуудын албан хаагчид хамрагдсан. **Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг үнэлэх аргачлалын дагуу 10 бүлэгт хувааж үнэлэн нийт 141 оноо авахаас 92 оноо авч 65,2 хувьтай** байна.

2. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж нийт 66 хүний бүрэлдэхүүнийг шинэчлэв.
3. Сумын онцгой комисс цахимаар 03-р сард 1 удаа нийт гишүүдийн 66.7 хувийн ирцтэй хуралдсан. Хурлаар 3 асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргасан. 1. Шүлхий өвчний тархалт, 2.Нөөцийн махыг тээвэрлэх, 3. Сумын аюулгүй нөөцийн өвсийг тараах зэрэг асуудал байна. Сумын шуурхай штабын үйл ажиллагааг идэвхжүүлж 70511111 утас, skype нэгдсэн цахим системийг хяналтад авч ажиллаж байна.
4. Баруун-Урт цахим хаягаар болон тамгын газрын дотоод мэдээллээр ХАА-н чиглэл болон гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор 6 мэдээллийг бэлтгэн 504 иргэнд хүргэж ажилласан.
5. Төрийн дээд одон медалиар шагнуулахаар өргөн мэдүүлсэн 36 иргэний материалыг Сумын Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж 100% дэмжин Аймгийн Засаг даргын Тамгын газарт илгээгдсэн.
6. Спорт хамтлагийн төлөвлөгөөний дагуу тамгын газрын албан хаагчдын заалны цагийг тогтмол болгох, Эртэч монгол аяны хүрээнд 3 дахь өдрийн өглөөний 6:30-7:30 минутад албан хаагчдыг хамруулах, Ханан жем фитнесд албан хаагчдыг хамруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Тайлангийн нэгтгэл хийсэн: Хүний нөөцийн ажилтан Б.Болортуул

Тайлантай танилцсан: Тамгын газрын даргын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч Б.Сарангэрэл

2022.03.24